

2

НЭЭЛТТЭЙ ЭДИЙН ЗАСГИЙН ТЭНЦВЭР**Т.Оюунбаатар**

Монгол улс нь хөгжиж буй орон. Өнөөдөр дэлхийн эдийн засаг улам бүр либералчлагдсаар байна. Энэ нөхцөлд дэлхийн улс орнуудын өмнө тулгараад буй асуудал нь ядуурлыг бууруулах, эдийн засгийн өндөр өсөлтийг хангах явдал. Магадгүй энэ нь эдийн засгийн урт хугацааны зорилт, стратеги. Тэгвэл эдийн засгийн өндөр өсөлтийн урьдчилсан нөхцөл нь макро эдийн тогтвортой байдал гэдэг үзэл, онол нэгэнт туршлагаар нотлогдсон билээ. Зүүн Өмнөд Азийн эдийн засгийн түргэн өсөлт нь үүний хамгийн сайн жишээ юм. Тэгэхээр нээлттэй эдийн засгийн хувьд амаргүй ч гэлээ эдийн засгийн тогтворжилтыг хангах асуудал чухлаар тавигддаг. Хөгжиж буй орнуудын эдийн засаг нээлттэй байх нь газрын тосны үнийн өсөлт, олон улсын капитал урсгал зэрэг гадаад шокын нөлөөнд эмзэг байдаг нь энэ асуудлыг авч үзэхэд хүргэдэг.

Макро эдийн засгийн тэнцвэр буюу тогтвортой байдал түүнд хүрэх макро бодлогыг шинжилсэн нээлттэй эдийн засгийн загварууд хэд хэд байдаг. Хамгийн их түгсэн нь Mundell-Fleming-ийн загвар билээ. Энэ загварт мөнгөний бодлого болон сангийн бодлогын үр ашигтай байдлыг шинжилдэг хэдий ч хамгийн гол дутагдалтай тал нь эдийн засгийн нийт

нийлүүлэлтийн талыг орхигдуулдаг билээ. Ийм учраас энэ удаад “Хоёр секторт нээлттэй эдийн засгийн загвар”-ыг сонгон дээрх асуудлыг шинжилсэн болно. Энэ загвар нь анх Salter (1959)-ын ажилд үндэслэгдэж, хожим Gorden (1981) өргөтгөл хийжээ.

Хөгжиж буй орнуудын эдийн засгийн хоёр онцлог байдаг. Нэгдүгээрт нь, эдийн засгийн нээлттэй байдалтай холбоотой. Олон улсын худалдаа болон капиталын урсгал нь тэдний дотоод эдийн засагт хангалттай нөлөө үзүүлдэг. Хоёрдугаарт нь, эдгээр эдийн засаг нь жижиг. Энэ нь тэдгээр орны экспортын нийлүүлэлт болон импортын эрэлтийн аль нь ч дэлхийн зах зээлийн үнэд мэдэгдэхүйц нөлөө үзүүлэхгүй гэсэн үг юм. Эдийн засагчид үүнийг дэлхийн зах зээлийн үнийг хүлээн авагч гэж хэлдэг. Жижиг, нээлттэй гэсэн энэхүү 2 шинж нь Salter-Gorden-ы загварын үндэс болдог. Мэдээж хэрэг ганц хоёр тохиолдлыг эс тооцвол энэ 2 шинжийг хөгжиж буй орны эдийн засгаас олж харж болно.

Макро эдийн засгийн тэнцвэр

Макро эдийн зорилгыг “Урт хугацаанд амьжиргааны түвшний боломжит өндөр өсөлтийг хангахын зэрэгцээ богино хугацаанд эдийн засгийн гадаад дотоод тэнцвэрийг хангах” гэж тодорхойлдог. Гадаад тэнцвэр нь урсгал тооцооны тэнцлээр тодорхойлогддог бол ажилгүйдэл, инфляци нь эдийн засгийн дотоод тэнцвэрийг алдагдуулж байдаг. Түүнчлэн гадаад, дотоод тэнцвэрүүдийн нэг нь хангагдахын хэрээр нөгөө нь алдагдаж байдаг.

Макро эдийн засгийн тэнцвэр нь загварт хэрхэн тодорхойлогдохыг авч үзье. Энэхүү загварт худалдагдах ба худалдагдахгүй гэсэн 2 секторт эдийн засгийг авч үздэг.

Худалдагдах сектор нь дотоодын үнэ нь дэлхийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтээр тодорхойлогддог бараа үйлчилгээнүүдийн зах

зээлээс бүрддэг. Энэ нь экспортын болон импортын бүтээгдэхүүнүүд гэсэн үг. Дэлхийн зах зээлийн үнийг экзогени гэж үзнэ. Өөрөөр хэлбэл, загварын гаднаас өгөгдөнө гэсэн үг. Худалдагдах бүтээгдэхүүнүүдийн эрэлт, нийлүүлэлт өөрчлөгдсөн ч дотоодын үнэд нөлөө үзүүлэхгүй. Харин валютын ханшны зохицуулалт нь дотоодын үнийг өөрчлөнө.

Худалдагдахгүй сектор нь тээвэр, барилга, жижиглэн худалдаа, өрхийн үйлчилгээ гэх мэт тээврийн зардлын улмаас дэлхийн зах зээлд гаргах боломжгүй бараа үйлчилгээний зах зээлүүд юм. Худалдагдахгүй бүтээгдэхүүний үнийг тодорхойлогч хүчин зүйл нь энэ секторын эрэлт нийлүүлэлт. Өөрөөр хэлбэл, энэ секторын үнэ нь эндогени хувьсагч болно.

Худалдагдах секторын үнийг P_t , худалдаалагддаггүй секторын үнийг P_n гэж тэмдэглэе.

Энэхүү эдийн засгийн тэнцвэрийг авч үзвэл дараах графикт дүрслэгдэнэ.

Зураг 1.



Босоо тэнцлэгт нь худалдагдахгүй бүтээгдэхүүнийг (N), хэвтээ тэнцлэгт нь худалдагдах бүтээгдэхүүнийг (T) авав. Үйлдвэрлэлийн боломжийн

муруй нь эдгээр хоёр бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх боломжит хослолуудыг харуулж байхад нийгмийн ялгаагүйн муруй нь эдгээр бүтээгдэхүүнүүдийн хэрэглээнээс авах хэрэглэгчийн таашаалыг харуулна.

Эдийн засгийн тэнцвэр E цэгт тогтоно. Энэ цэгт үйлдвэрлэлийн боломжийн муруй болон хэрэглэгчийн ялгаагүйн муруйнууд шүргэлцэх бөгөөд худалдагдах бүтээгдэхүүний үйлдвэрлэл нь энэ бүтээгдэхүүний эрэлтээр тодорхойлогдож T_1 хэмжээтэй байна. Мөн энэ цэгт худалдагдахгүй бүтээгдэхүүний үйлдвэрлэл нь N_1 хэмжээтэй байх ба эрэлт нийлүүлэлт нь тэнцүү байна. Тиймээс энэ загварын тэнцвэр нь E цэг дээр тодорхойлогдох бөгөөд тэнд хоёр бүтээгдэхүүний зах зээлүүд нь тэнцвэртэй байна. Үүнийг өөрөөр эдийн засгийн макро тэнцвэр хангагдсан байна гэж хэлдэг. Учир нь худалдагдах бүтээгдэхүүний эрэлт нийлүүлэлт тэнцүү тул эдийн засгийн гадаад тэнцвэр хангагдах ба худалдагдахгүй бүтээгдэхүүний эрэлт нийлүүлэлтийн тэнцвэржилт нь эдийн засгийн дотоод тэнцвэрийг ч хангана.

Нэмж хэлэхэд, ялгаагүйн муруй болон үйлдвэрлэлийн боломжийн муруйн налалтууд харьцангуй үнийг тодорхойлдог. Харьцангуй үнэ нь нэг нэгж худалдагдахгүй бараагаар илэрхийлэгдэх худалдагдах барааны үнэ юм. Энэ үнийг P -ээр тэмдэглэсэн байгаа. Харьцангуй үнийн өөр нэг хэмжүүр нь бодит валютын ханш.

Хэрэв харьцангуй үнэ өсвөл (зураг дээр үнийн шулуун илүү хэвтээ болно) худалдагдах бүтээгдэхүүн харьцангуй үнэтэй болно. Тэгвэл үйлдвэрлэгчид худалдагдахгүй барааны үйлдвэрлэлээс худалдагдах барааны үйлдвэрлэл рүү үйлдвэрлэлийн боломжийн муруйн дагуу шилжихийг чармайна. Харин хэрэглэгчид ялгаагүйн муруйн дагуу эсрэг чиглэлд шилжихийг оролдоно. Тиймээс харьцангуй үнийн өсөлт нь худалдагдах барааны илүүдлийг бий болгоно. Хэрэглээнээс давсан хэт үйлдвэрлэл явагдана гэсэн үг. Энэ нь эдийн засгийн гадаад тэнцвэр

алдагдах буюу худалдааны тэнцэл илүүдэлтэй болно гэсэн үг юм. Үүнийг дараах адилтгалаас хялбархан харж болно.

Экспорт, импортыг X , M -ээр, худалдагдах бүтээгдэхүүний эрэлт, нийлүүлэлтийг D_t , S_t -ээр тэмдэглэе. Худалдааны тэнцэл нь (NX) экспорт импортын зөрөө ба худалдагдах бүтээгдэхүүн нь экспортын ба импортын бүтээгдэхүүн гэдгийг санавал

$$NX_t = X - M$$

=экспортын бүт-ий нийлүүлэлтийн өртөг - экспортын бүт-ий

эрэлтийн өртөг

-(импортын бүт-ий эрэлтийн өртөг - импортын бүт-ий

нийлүүлэлтийн өртөг)

= экспортын бүт-ий нийлүүлэлтийн өртөг+ импортын бүт-ий

нийлүүлэлтийн өртөг

-(экспортын бүт-ий эрэлтийн өртөг+ импортын бүт-ий эрэлтийн өртөг)

=худалдагдах бүт-ий нийлүүлэлтийн өртөг – худалдагдах бүт-ий

эрэлтийн өртөг

$$NX_t = P_t S_t - P_t D_t = P_t (S_t - D_t) \text{ болно.}$$

Зураг дээр харуулсан эдийн засгийн тэнцвэрт худалдагдах бүтээгдэхүүний үйлдвэрлэл нь эрэлттэйгээ тэнцүү, иймээс худалдааны тэнцэл нь тэг байна. Өөрөөр хэлбэл эдийн засгийн гадаад тэнцвэр хангагдана.

Үндэсний орлогын тооцоог хийж үзүүлье. Дотоодын нийт бүтээгдэхүүн нь худалдагдахгүй (N_1) болон худалдагдах (T_1) бүтээгдэхүүний өртгийн нийлбэрээр тодорхойлогддог. Энэ өртөг нь зураг дээр харьцангуй үнийн шулууны хэвтээ тэнхлэгтэй огтлолцсон Y_1 цэгээр тодорхойлогдоно. Y_1 цэгээс T_1 цэг хүртэлх зай нь N_1 хэмжээний худалдагдахгүй

бүтээгдэхүүний худалдагдах барааны үнээр илэрхийлэгдсэн өртөг болно. Иймд Y_1 нь худалдагдах барааны үнээр илэрхийлэгдэх дотоодын нийт бүтээгдэхүүн буюу үндэсний нийт орлого юм. Томьёолбол

$$Y = C + I + X - M$$

Энд C ба I нь хувийн болон улсын секторыг хоёуланг нь агуулсан нийт хэрэглээ ба нийт хөрөнгө оруулалт.

Үндэсний орлогын тооцоон дахь өөр нэг ялгаатай ойлголт нь дотоодын нийт зардал (эрэлт) буюу absorption юм. Үүнийг нийт эдийн засгийн шингээх чадвар ч гэж нэрлэдэг. Энэ нь дараах байдлаар тооцогддог.

$$A = C + I = Y + M - X$$

Зураг дээр үзүүлсэн эдийн засгийн тэнцвэрт экспорт импорт нь тэнцүү ($X=M$) байх тул дотоодын нийт орлого нь нийт зардалтайгаа тэнцүү байна. Өөрөөр хэлбэл $Y=A$ нөхцөл нь тэнцвэрийг тодорхойлох нөхцөл болж байна.

Дээрх бүгдийг нэгтгэвэл 3 үр дүнг хэлж болохоор байна.

1. Макро эдийн засгийн тэнцвэр нь 2 төрлийн бүтээгдэхүүний зах зээлийн тэнцвэрээр буюу эдгээр бүтээгдэхүүний эрэлт, нийлүүлэлтийн харилцан үйлчлэлээр тодорхойлогдоно. Худалдагдах барааны зах зээлийн тэнцвэр нь эдийн засгийн гадаад тэнцвэр, худалдагдахгүй барааны зах зээлийн тэнцвэр нь эдийн засгийн дотоод тэнцвэр болно.
2. Дээрх хоёр төрлийн зах зээлүүд тэнцвэрт хүрэхийн тулд хоёр нөхцөл хангагдах ёстой. Эхнийх нь дотоодын нийт зардал нь нийт орлоготой тэнцүү байх. Хоёрдугаарт нь, харьцангуй үнэ (бодит валютын ханш) нь хоёр зах зээлийн эрэлт нийлүүлэлтийг тэнцвэржүүлж байх явдал юм.
3. Хэрэв эдийн засаг нь тэнцвэртэй бус бол эдийн засгийг тэнцвэрт хүргэх төрийн бодлогын 2 хэрэгслийг санал болгодог. Эдгээр нь


дотоодын нийт зардал (A) болон нэрлэсэн валютын ханшны бодлогууд. Ерөнхийдөө эдгээр хэрэгслээр дамжуулан эдийн засгийг тэнцвэржүүлж чадах бөгөөд эдийн засгийн гадаад, дотоод тэнцвэрийг зэрэг хангахын тулд хоёлуанг нь ашиглах хэрэгтэй гэж үздэг.

Фазын диаграмм


Жижиг нээлттэй эдийн засгийн макро тэнцвэрийн загварыг авч үзлээ. Эдийн засгийн тэнцвэрт хүрэх макро эдийн засгийн менежмент буюу тогтворжуулах бодлогын зарчмыг илүү тодорхой, ойлгомжтой болгохын фазын диаграммын аргыг авч үзье. Үүний тулд худалдагдах болон худалдагдахгүй бүтээгдэхүүний зах зээлийг уламжлалт эрэлт, нийлүүлэлтийн график дээр авч үзье.

Графикийн босоо тэнхлэгт бодит валютын ханш буюу T барааны N бараагаар илэрхийлэгдэх харьцангуй үнийг (P_t/P_n) авч үзнэ.

Зураг 2.



I. Худ-дах бүт-ий 33



II. Худ-гүй бүт-ий 33


Эхний зураг дээр худалдагдах барааны эрэлт нийлүүлэлт өгөгджээ. Үнэ нь өсөхөд нийлүүлэлт нь нэмэгдэж, эрэлт нь буурна. Дараагийн зураг дээр нь худалдагдахгүй барааны эрэлт нийлүүлэлт өгөгдсөн. Харин энд үнэ өснө гэдэг нь энэ бүтээгдэхүүний (N) харьцангуй үнэ

буурах учраас нийлүүлэлт нь буурч, эрэлт нь өснө. Харин аль ч зах зээл дээр нийт зардлын өсөлт нь эрэлтийн муруйг гадагш нь шилжүүлэх бөгөөд үнийн түвшин бүрт хэрэглэгчид аль ч бараанаас ихийг худалдан авна гэсэн үг юм.

Дээрх график нь жижиг нээлттэй эдийн засгийн энгийн загварыг илэрхийлнэ. Энэ нь 2 хувьсагч дээр үндэслэгдэж байна. Босоо тэнхлэг дээрх бодит валютын ханш ба эрэлтийн муруйн байрлалыг тодорхойлох дотоодын зардал (A). Микро эдийн засагт бол үнэ ба орлого гэсэн хувьсагчид байх болно. Харин энэхүү загварт валютын ханш болон зардлын түвшин нь төрийн макро бодлогын гол хэрэгслүүд билээ. Өөрөөр хэлбэл, эдгээр хувьсагчид нь макро менежментийн цөмд байдаг. Ийм учраас илүү тодорхой болгохын тулд тэдгээр хувьсагчдыг тэнхлэг дээр нь байрлуулсан графикийг авч үзье.

Дараах гарфикийн босоо тэнхлэгт нь бодит валютын ханшийг, хэвтээ тэнхлэгт нь нийт зардлыг авсан бөгөөд зураг дээрх 2 муруй нь тус бүрдээ нэг бүтээгдэхүүний зах зээл дээрх тэнцвэрийг харуулна. EB муруйн дагуу гадаад тэнцвэр буюу Т барааны зах зээлийн тэнцвэр ($S_T = D_T$) хангагдана. Харин IB муруйн цэгүүд нь дотоод тэнцвэр буюу N барааны зээлийн тэнцвэр ($S_N = D_N$) хангагдаж байгааг харуулна.

Зураг 3.



Түүнчлэн графикт эдийн засгийн тэнцвэргүй байдлын бүсүүдийг харуулав. Т барааны зах зээл дээр (А хэсэгт) дотоодын зардалын өгөгдсөн түвшинд (тухайлбал A_1) бодит ханш нь P_1 -ээс их бол (P_2) гадаад тэнцвэр нь илүүдэлтэй байна. Худалдагдах бүтээгдэхүүний үйлдвэрлэл нь эрэлтээсээ давна гэсэн үг бөгөөд зах зээл тэнцвэржихийн тулд харьцангуй үнэ буурах ёстой. Эсрэг тохиолдолд гадаад тэнцвэр алдагдалтай байна. Худалдагдах барааны эрэлт нь нийлүүлэлтээсээ давсан гэсэн үг.

N барааны зах зээл дээр (Б хэсэгт) IB муруйн баруун тал нь инфляцитай эдийн засгийг төлөөлнө. Энэ бүсэд бодит ханшийн өгөгдсөн түвшинд (тухайлбал P_1) дотоодын зардлын илүү өндөр түвшин (A_3) харгалзана. Ийм учраас худалдагдахгүй барааны эрэлт нь нийлүүлэлтээсээ илүү байна. Дотоод тэнцвэрийн муруйн зүүн тал нь ажилгүйдлийн бүс бөгөөд N барааны нийлүүлэлт нь илүү байна. Өөрөөр хэлбэл, бодит ханшийн өгөгдсөн түвшинд (P_3) дотоодын зардал нь бага (A_1) байна.

Энэ загварт яригдаж ажилгүйдэл инфляцийг бодит байдалд хэрэглэгддэг утгаас нь арай өөрөөр ойлгож байгааг анхаарна уу. Инфляци нь үнийн түвшний хэвийн өсөлтөөс илүү хурдан өсөлт гэж ойлгогдоно. Харин ажилгүйдэл нь ажилгүй хүмүүсээс гадна үйлдвэрлэлийн бусад хүчин зүйлийн сул зогсолтыг ч багтааж байгаа. Өөрөөр хэлбэл, эдийн засаг нь ажилгүйдэлтэй байна гэдэг бол үйлдвэрлэлийн боломжийн муруйн дотоодод эдийн засаг байна гэсэн үг.

Дараах графикт тэнцвэрийн муруйнуудыг хамтад нь дүрслэв. EB муруйн дагуу Т барааны эрэлт нийлүүлэлт тэнцүү. Харин IB муруйн цэгүүд нь N барааны эрэлт нийлүүлэлт тэнцүү байгааг харуулна. Ийм учраас зөвхөн E цэг дээр л худалдагдах болон худалдагдахгүй бүтээгдэхүүний зах зээлүүд тэнцвэртэй байх буюу эдийн засгийн

Зураг 4.




гадаад дотоод тэнцвэр зэрэг хангагдана. Энэ цэг дээр нийгмийн ялгаагүйн муруй болон үйлдвэрлэлийн боломжийн муруйн налалтууд тэнцүү байна. Валютын ханш болон дотоодын зардлыг зохицуулан макро бодлогын зорилго нь эдийн тэнцвэртэй байдал буюу E цэг дээрх гадаад дотоод тэнцвэрийг хангах явдал юм.

Түүнчлэн эдийн засгийн тэнцвэргүй байдлын 4 бүсийг зурагт үзүүлжээ. I мужид эдийн засаг нь инфляцитай ба гадаад тэнцвэр нь илүүдэлтэй байна. Энд валютын ханш нь доогуур үнэлэгдэнэ (undervalued). II мужид эдийн засаг инфляцитай байх ба илүүдэл эрэлтийн улмаас гадаад тэнцвэр алдагдалтай байна. III мужид валютын ханш хэт үнэлгээтэй (overvalued) байх бөгөөд эдийн засаг нь ажилгүйдэл, гадаад алдагдалтай байна. IV мужид нийт зардлын

хүрэлцээгүйн улмаас эдийн засаг нь ажилгүйдэл, гадаад илүүдэлтэй байна.

Эдийн засаг тэнцвэрээсээ гарах буюу эдийн засгийн тэнцвэр алдагдсан тохиолдолд макро тэнцвэр хэрхэн тогтох вэ? Энэ асуултад загвар өөрөө хариулт өгөх бөгөөд эдийн засаг тэнцвэрт бус байсан ч тэнцвэр лүүгээ тэмүүлэх хандлагатай байдаг. Өөрөөр хэлбэл тэнцвэр лүү түлхэх эдийн засгийн хүч үйлчилж байдаг. Үүнийг илүү тодорхой үзье.

Зураг 5.



Гадаад тэнцвэр илүүдэлтэй байх А цэгээс эхлээ. Худалдах барааны илүүдэл нийлүүлэлт нь өөрөө өөрийгөө залруулах хандлагыг бий болгоно. Нэгдүгээрт нь гадаад валютын цэвэр дотогшлох урсгал нь олон улсын валютын нөөцийг нэмэгдүүлнэ. Хэрвээ Төвбанк үүний эсрэг арга авахгүй бол мөнгөний нийлүүлэлт нэмэгдэж, зээлийн хүү буурах болно. Энэ нь эргээд хэрэглээний болон хөрөнгө оруулалтын зардлыг урамшуулснаар эдийн засаг тэнцвэрийн EB муруйг чиглэн баруун тийш шилжих юм. Хоёрдугаарт нь гадаад валютын цэвэр дотогшлох урсгал нь дотоод валютын илүү их эрэлт бий болгоно. Энэ нь хөвөгч ханшны системтэй эдийн засагт ханш өсөхөд (чангарах)

хүргэнэ. Энэ нь мөн л тэнцвэрийн муруй луу доошоо чиглэх болно. Энэ хоёр үр дүнгийн хослол нь зурагт бүдүүнээр тэмдэглэсэн чиглэлийн дагуу тэнцвэр лүү тэмүүлэхэд хүргэнэ. Үүний адилаар, хэрэв эдийн засаг В цэгээс эхлэх бол гадаад тэнцвэр сэргэх хандлага үргэлжилнэ.

Дотоод тэнцвэр ч мөн өөрийгөө сэргээх хандлагатай. Эдийн засаг инфляцитай байх тохиолдолд тэр нь бодит ханш, бодит зардлын аль алинд нь нөлөөлнө. Хэрвээ нэрлэсэн валютын ханш тогтмол (эсвэл ханшны уналт инфляцийн хурдыг гүйцэхгүй бол) P_n -ийн өсөлт нь бодит ханш чангарах (appreciation) шалтгаан болно. Үүнтэй нэгэн зэрэг мөнгөний нийлүүлэлт нэмэгдээгүй тохиолдолд үнийн өсөлт нь зардлын бодит өртгийг бууруулах шалтгаан болно. Эдгээр үр дүн нь эдийн засаг инфляцитай байгаа тухайлбал С цэгээс дотоод тэнцвэр лүү чиглэх болно. Түүнчлэн ажилгүйдлийн бүс (D цэг) ч өөрийгөө залруулах хүч үйлчилнэ.

Практикт тэнцвэр хэр шулуун, хурдан сэргэх нь эдийн засгийн бүтцийн уян хатан байдлаас шалтгаалдаг.

Тогтворжуулах бодлого


Эдийн засгийн макро тэнцвэр сэргэхэд практикт бүтцийн эсвэл бодлогын зөрчил зэрэг саад учирдаг. Ихэнх тохиолдолд эдийн засгийг тогтворжуулахад Засгийн Газар идэвхтэй үүрэг гүйцэтгэх хэрэгтэй болдог. Валютын ханшийг удирдах, сангийн бодлого, мөнгөний бодлогоор дамжуулан үүнийг хийх хэрэгтэй болдог.

Эдийн засгийн төлөв байдлаас хамааран эдгээр бодлогын ямар чиглэл хэрэгтэйг график ашиглан харуулья. Энэхүү бодлогын жорыг зураг 6-д харуулав.

Гадаад дотоод тэнцвэрийн муруйнууд нь өмнө нь дүрсэлж байсантай адил. Харин шинээр нэмэгдсэн зүйл бол бодлогын 4 муж юм. Эдгээр нь тасархай зураасаар хуваагдах бөгөөд I, II, III, IV гэж тэмдэглэгдсэн. Эдгээр мужуудад ямар макро бодлого явуулах вэ гэдгийг авч үзье.

I мужаас эхлээ. Тухайлбал 1 цэгийг авч үзье. Энд гадаад тэнцвэр хангагдаж эдийн засагт инфляцийн дарамт бий болсон байна. Олон жилийн туршид Бразил ийм нөхцөл байдалд байв. Худалдахгүй барааны илүүдэл эрэлтийн улмаас сангийн болон мөнгөний хумих бодлогоор бодит зардлыг бууруулах шаардлагатай. Зөвхөн энэ бодлогыг явуулснаар эдийн засагт тэнцвэрт хүрэхгүй. Гадаад илүүдэл бий болж 4 цэгт очих болно. Энэ нь нэг тэнцвэрийг нөгөөгөөр солино гэсэн үг. Үүнээс зайлсхийхийн тулд хумих бодлогыг валютын ханшны өсөлт дагалдах хэрэгтэй. Ингэх аваас эдийн засаг тэнцвэр лүүгээ тэмүүлэх болно.

Зураг 6.



Энэ үр дүнгийн талаар 2 зүйлийг тэмдэглэх хэрэгтэй.

1. Бодлогуудын энэ хослол нь (хумих ба ханшны өсөлт) I мужид орших аль ч цэгт үйлчлэх бөгөөд эдийн засгийг тэнцвэрт хүргэж чадна. Энэ нь бодлогын зөв хослол хэдий ч аль бодлогыг илүү эрчимтэй явуулах нь эдийн засаг энэ мужийн хаанаас эхлэхээс хамаарах нь ойлгомжтой бизээ.
2. Ерөнхийдөө эдийн засгийг тэнцвэрт хүргэхийн тулд хоёр бодлогын зохицуулалт шаардлагатай. Энэ дүрмийг эдийн засгийн салбарт анхны Нобелийн шагналыг хүртсэн Голландын эдийн засагч Jan Tinbergen илэрхийлсэн юм. Тэрээр макро зорилтуудад хүрэхийн тулд түүнтэй ижил тооны бодлогын хэрэгсэл зайлшгүй хэрэгтэйг цохон тэмдэглэсэн. Тиймээс гадаад дотоод тэнцвэрт хүрэх зорилтууд болон тэдгээрт хоёуланд нь хүрэхийн тулд бодит валютын ханш ба нийт зардал гэсэн хоёр зохицуулалт шаардлагатай.

Энэ зарчимтай адилаар бусад мужуудад ч ямар бодлого явуулбал зохистойг харуулж болно. Тухайлбал II мужид гадаад тэнцвэрийг сэргээхийн тулд девельваци хэрэгтэй. Зөвхөн энэ бодлогыг явуулбал эдийн засагт инфляцийн дарамт бий болно. Сангийн болон мөнгөний хумих бодлогоор инфляциас зайлсхийн тэнцвэрт хүрч чадна. Африкийн олонх орон 1970, 1980-аад онуудад ийм нөхцөл байдалд байсан билээ. III мужид сангийн болон мөнгөний тэлэх бодлого нь ажилгүйдлийг алга болгоно. Гэхдээ зөвхөн энэ бодлогыг явуулбал төлбөр нь гадаад тэнцвэрийн алдагдал байх болно. Иймээс мөн девельваци шаардлагатай. Энэ хоёр зохицуулалтаар эдийн засгийг тэнцвэрт хүргэж чадна. Энэхүү нөхцөл байдал нь хөгжиж буй орнуудын хувьд нийтлэг бус, харин аж үйлдвэржсэн эдийн засагтай орнуудын хямралын үеийн шинж юм. IV мужид валютын ханшийг өсгөх бодлого нь гадаад илүүдлийг арилгана. Зөвхөн энэ бодлого нь

эдийн засагт ажилгүйдлийн дарамт бий болгох учраас хамтад нь тэлэх бодлого явуулбал эдийн засаг дахь ажилгүйдлийн дарамтыг алга болгоно. Тайвань, Малайз зэрэг Азийн цөөн хэдэн улс 1980-аад онд энэ нөхцөл байдалд байсан билээ.

Эцэст нь тэмдэглэхэд, хэрвээ эдийн засаг хаана байгааг (4 мужийн) буюу ямар нөхцөл байдалд байгааг мэдэж байвал бодлого боловсруулагчдын хувьд эдийн засгийн тэнцвэрийг хангах тогтворжуулах бодлогын зарчим нь маш энгийн юм. Харин бодлого боловсруулагчдын хувьд эдийн засаг ямар нөхцөлд байгааг хэрхэн мэдэх вэ? Энэ асуултын хариултын нэг хэсэг нь хэмжилт, нөгөө хэсэг нь ур чадвар (урлаг) юм. Эконометрик загварууд нь эдийн засаг хаана байгааг, ямар бодлого хэрэгтэйг илэрхийлдэг.